

"МАЛЧДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ӨРГӨЖҮҮЛЖ, ЦОЧРОЛД
ХАРИУ ҮЗҮҮЛЭХ БЭЛЭН БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ"
ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР

"БЭЛЧЭЭРИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТЭД МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН АЧ ХОЛБОГДОЛ"

ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



УЛААНБААТАР ХОТ 2022 ОН

Агуулга

НЭГ.ОРШИЛ	4
1.1 Үндэслэл, ач холбогдол	4
1.2 Гарын авлагын тухай танилцуулга.	5
ХОЁР. СУРГАЛТАД БАРИМТЛАХ АРГА ЗҮЙ	6
2.1 Сургалтын онцлог, зарчим	6
2.2 Оролцогчдод өгөх нэмэлт мэдээлэл – 1	
2.3 Сургалтын арга зүй	6
2.4 Эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилтийн үндэс:	7
2.5 Цаашид авах арга хэмжээ, анхаарах асуудал	20
	27
ГУРАВ. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	29
	31
3.1 Танхимын бус сургалт үйл ажиллагааны тухай.	
3.2 Харилцан суралцах аргаар сургалтыг зохион байгуулах нь:	36
3.3 Тулгарч болох бэрхшээл, шийдвэрлэх аргууд	36
3.4 Оролцогчдод өгөх нэмэлт мэдээлэл – 2	36
ДӨРӨВ. СУРГАЛТЫН ДАРААХ ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ	36
	42
4.1 СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС	44
	44
	44
	51
	51

НЭГ.ОРШИЛ

1.1 Үндэслэл, ач холбогдол

Малын тоо хөөцөлдөн бэлчээрийн даац хэтрүүлэн их өсгөснөөс малын чанар, ашиг шим, малчдын орлого буурахын зэрэгцээ отрын нөөц нутаг, нэмэгдэл тэжээлийн хангамж хомсдож, байгалийн эрсдэлд улам бүр эмзэг болж байна.

Нөгөө талаар бэлчээр, эрсдэлийн менежмент, малын чанар, эрүүл мэндийг сайжруулах, байгаль хамгаалах нэн чухал ажлыг сумын төсвөөс санхүүжүүлэх заалттай ч төсвийн хүрэлцээгүй байдлаас эдгээр чиг үүргийн хэрэгжилт нэн хангалтгүй байна.

Хоорондоо нягт уялдаа бүхий дээрх хоёр асуудлыг цогцоор нь шийдэхэд саяхан батлагдсан малын тоо толгойн албан татварын тухай хууль онцгой ач холбогдолтой болж байна.

Дээрх хуулийг гаргасан зорилго, шалтгаанд нийцүүлэн хэрэгжүүлэх талаар бэлчээрийн менежмент, малчид, байгаль орчин, судалгааны чиглэлийн төрийн бус байгууллагууд нэгдэн нэн тодорхой зөвлөмж боловсруулсан байдаг. Хэрвээ энэ хуулийг хэрэгжүүлэхэд малчдын хүсэл сонирхлыг харгалзах, урьдын алдааг давтахгүй байх тал дээр анхаарал хандуулахгүй бол малчид татвар төлөхөөс зайлсхийх, төлсөн татварыг нь үр ашиггүй зарцуулах, мөн Засгийн газрын үйл ажиллагааг малчид буруугаар ойлгох эрсдэл байж болох юм.

Энэхүү гарын авлага нь шинэ татварыг бэлчээр ашиглалт, МАА-н үйлдвэрлэл, байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдэхэд бодитой хувь нэмэр оруулах бодлогын хөшүүрэг болгоход чиглэсэн бөгөөд татварын олон улсын нийтлэг зарчим, манай улсад туршигдаж, нутгийн захиргаа, малчдын дэмжлэгийг авсан загвар, тооцоо, судалгаанд суурилсан юм.

Нэн ялангуяа татварын орлогыг хуулиар заасан зориулалтын дагуу үр ашигтай зарцуулахад татвар төлөгч малчдын оролцоо, хяналтыг хангах, ижил орлогоос ижил татвар авах, бэлчээрээ даацад тохируулан зохистой ашиглаж байгаа малчдад хөнгөлөлт үзүүлэх замаар тэдний малаа зах зээлд борлуулах сонирхлыг дэмжих, татварын орлогыг зарцуулах чиглэл бүрээр сум, дүүргийн төсөвт суулгах хөтөлбөр, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн доод хязгаарыг зааж өгөх зэрэг нэн шаардлагатай зохицуулалтыг тусгасан болно.

Малчдад сургалт зохион байгуулах сургагч багш нар сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, амжилтад хүрэхийн тулд тэдний оролцоо, мэдлэг, туршлагад тулгуурласан арга зүйг сонгон хэрэглэх нь зүйтэй юм. Сургагч багш нар оролцогчдын хэрэгцээ, мэдлэг, туршлагын түвшнийг харгалзаж, сургалтын агуулга, хөтөлбөрийг уян хатан байдлаар зохион байгуулж болно. Энэхүү сургагч багшийн гарын авлагад оролцоонд суурилсан сургалтын аргууд, амжилттай суралцахуйн зарчим болон практик, сайн сургагч багш байх зөвлөмж, зорилтот бүлгийн онцлогийг харгалзах асуудал, насанд хүрэгчидтэй ажиллах зөвлөмж, малын ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл, технологийн танилцуулга хичээлийн заах арга зүйн талаар тусгасан болно.

1.2 Гарын авлагын тухай танилцуулга

“Бэлчээрийн тогтвортой менежментэд малын тоо толгойн албан татварын ач холбогдол” модуль нь малчдад сургалт зохион байгуулах сургагч багшийн ашиглах гарын авлага бөгөөд багш нарт арга зүйн зөвлөгөө өгөх, сургалтыг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах арга замуудын үлгэрчилсэн төлөвлөгөөг шингээж өгснөөрөө онцлог юм.



Энэхүү модуль, гарын авлагын гол ач холбогдол нь Бэлчээрийн мал аж ахуйн онцлог нөхцөл байдлыг тухайн сум, аймгийн экологийн ямар бүсэд хамаарч байгаа, энэ бүс нутгийн уур амьсгал, нутаг бэлчээрт хамгийн сайн дасан зохицсон, эдийн засгийн ашиг орлого илүүтэй, байгаль орчиндоо сөрөг нөлөөгүй, мал сүрэг, бэлчээр хоёр нь харилцан ашигтай байх нөхцөлийг бүрдүүлэх менежментийг хэрэгжүүлэх эдийн засгийн хөшүүргийг олон талаас нь сайтар судлан, зөв тогтоох сэдлийг малчны гэрт хүргэж байгаа явдал юм. Иймд багш нар энэхүү агуулгыг малчдад хүргэхдээ тэдний арга, туршлагыг сонсох, амьдралын үнэт зүйл, мэдлэг чадвар дээр нь тулгуурлан хэлэлцүүлэг зохион байгуулах, хооронд нь сайн туршлагыг нь солилцуулах зэргээр арга зүйн шийдлүүдийг гаргаж ажиллаарай

ХОЁР. СУРГАЛТАД БАРИМТЛАХ АРГА ЗҮЙ

2.1 Сургалтын онцлог, зарчим

Сургалт гэдэг нь тухайн хүнд ажил, даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай ерөнхий болон тодорхой, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлагыг хөтөлбөрийн дагуу олгодог зохион байгуулалттай үйл ажиллагаа юм. Энэхүү сургалтад малчин иргэд оролцох тул янз бүрийн насны, өөр өөр мэдлэг туршлагатай, өөр өөр түвшний мэдлэг мэдээлэлтэй хүмүүс

байгаа гэж үзээд гэж үзээд насанд хүрэгчдийн сургалтын арга зүйгээр зохион байгуулах нь зүйтэй юм. Насанд хүрэгчдийн сургалт нь ЕБС, дээд сургуулийн сургалтын арга зүйгээс ялгаатай. Иймд сургагч багш та сургалт зохион байгуулахдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

1. Сургалтад оролцогчдын манлайлал, идэвхтэй оролцоо /Сургалтад оролцож байгаа малчин иргэдийн оролцоог бүрэн хангах, нүүр хагарах, багийн үйл ажиллагаанд манлайлан оролцох, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх сэтгэлзүйн болон үйлийн орчныг бүрдүүлж ажиллах/
2. Сургалтын орчин аюулгүй, тайван байх
3. Сургалтын материал ач холбогдол сайтай, өгөөжтэй байх /сургалтаар өгөгдөж буй хэрэглэгдэхүүн санаа сэдэл үүсгэхүйц үр ашиг, өгөөжтэй байх, видео хичээл болон хэрэглэгдэхүүний ач холбогдлыг тооцоолон, хэлэлцэх асуулт бүрийг өгөөжтэйгөөр боловсруулах/
4. Хүртэхүйн олон тал хэлбэрийг ашиглан сургалтаа зохион байгуулах /Ярилцах, сонсох, оролцох, хийх, бүтээх, илтгэх. Оролцогч өөрөө хийж бүтээж, судалж илтгэсэн бүхэн эргээд хүнд тогтдог тул насанд хүрэгчдийн сургалтын арга зүйгээр оролцоог хангах, идэвхжүүлэх/
5. Практик хэрэглээ /Сургалтад авч буй жишээ, кейс тохиолдол амьдрал, практик, уламжлал, хэрэглээнд илүү ойр байх /
6. Эргэх холбоо
7. Сэдэл тэмүүлэл Сургалтад баримтлах арга зүйн гол шийдэл нь янз бүрийн насны малчин иргэдтэй харилцах учир ярилцлага болон хэлэлцүүлэг хэлбэрээр явуулбал илүү үр дүнтэй байх болно. Учир нь тэд өөрийн туршлагаа бусдад түгээх, санал бодлоо солилцох зэргээр хөгжих боломжтой.

2.2 Оролцогчдод өгөх нэмэлт мэдээлэл–1

Мал сүрэг идээшлүүлсний дараа, эсвэл өвсийг нь хадаж авсны дараа бэлчээрийн ургамал төлжин ургахад 24–30 хоног, хоёр дахь удаагаа таслахад 36–50 хоног шаардагддаг байна. Яг энэ үеийг заавал тооцоолж, бэлчээрийн ачааллыг бууруулж, зохицуулахгүй бол ургамал, ургац, төрөл зүйл, үржил шим жил ирэх тутам улам доройтдог. Иймээс уламжлалт нүүдлийн аж ахуйн гол арга технологи болсон нүүдэл хийх, бэлчээрээ сэлгэн амрааж ашиглах нь маш их ач холбогдолтой.

С.Цэрэндаш нар эрдэмтдийн 2000 онд хийсэн судалгаанд өнтэй жил дунджаар 86 сая гаруй хонь, харин урьд зун нь гантай жил 57 саяас хэтрүүлэхгүй байх, өөрөөр хэлбэл 100 га бэлчээрийн талбайд 62 хонь бэлчээрлүүлэх экологийн даацтай гэж тооцсон байна.

Бэлчээрийн хөрс талхлагдаж нягтарснаар ус, чийг, агаар нэвтрүүлэх горим алдагдана. Энэ нь ургамлын үндэсний өсөлт хөгжилтөд сөргөөр нөлөөлж эхэлнэ.

Бэлчээр соргог байх үед нэг га–д найман тонн үндэс агуулагддаг байсан бол талхлагдсан бэлчээрт түүнээс хоёр дахин бага буюу дөрвөн тонн болдог байна. Соргог бэлчээрийн газрын хөрсний ус нэвтрүүлэх чадварыг шинжилж үзэхэд, 141.9 мм цаг байгаа бол талхлагдсан бэлчээрийнх 70.8 мм цаг болж хөрсний ус нэвтрүүлэх чадвар хоёр дахин буурсан байна.

Тал хээрийн соргог бэлчээрийн сүвшилт (агаар, ус нэвтрүүлэх) 3–7 см-ийн гүнд 56 хувь, 12–16 см-ийн гүнд 55.2 хувь байгаа бол талхлагдсан бэлчээрийнх 3–7 см-ийн гүнд 53.7 хувь болж хөрсний өнгөн үеийн сүвшилт 4.1 хувиар буурсан байна.

Доктор Д.Аваадорж, Я.Баасандорж нарын хийсэн судалгаагаар 1960–аад оны үетэй харьцуулахад 2000 оны эхэнд хийсэн судалгаагаар бэлчээрийн га-гийн ургац хоёр дахин, ургамлын зүйлийн бүрэлдэхүүн мөн хоёр дахин буурсныг тогтоосон байна. Тухайлбал, ойт хээрийн ургамлын зүйлийн төрөл 48 байснаа 23 болж буурсан бол, хээрийнх 33 байснаа 16, цөлөрхөг хээрийнх 23–аас 12 болж, харин цөлийн бүсийнх 16–аас 11 болтлоо буурсан байна. Энэ нь малын идэш тэжээлийн амт, шимт чанар буурч байна.

Манай эрдэмтдийн судалж тогтоосноор соргог бэлчээрт идээшилсэн, дулаан байр хэвтэртэй бог малын амьдын жингийн алдагдал өвлийн улиралд дунджаар зургаан кг орчим байхад, зун намартаа талхлагдсан шим муутай бэлчээрт байлгасан малын амьдын жин дунджаар 10 кг–аар буурдаг байна.


Арваад жилийн өмнө малчид мал сүргийг хонин толгойд шилжүүлж, татвар төлдөг байжээ. Тухайлбал, нэг адууг таван хоньтой дүйцүүлж, татвар авдаг байсан төдийгүй татварын хувь хэмжээг бүсчилж, ялгаатай тогтоодог байжээ. Тодруулбал, алс хязгаар аймгуудад нэг хонинд 50, төвийн бүс нутагт 75, нийслэл орчимд 100 төгрөгийн татвар ногдуулдаг байсан аж. Нэг суманд дунджаар энэ төрлийн татвараас жилд 5–6 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Тиймээс малын тоо толгойн албан татвар малын чанарыг сайжруулах, бэлчээрийн доройтлыг бууруулах, нөхөн сэргээх боломж бий болж байна.

Манай улсын мал, сүргийн тоо сүүлийн 30 жилд 45.1 сая тоо толгойгоор нэмэгдэж байгаа нь хүн амын хүнсний хэрэгцээ, малчдын амьжиргаа, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөтэй ч өсөн нэмэгдэж байгаа малын тоо толгой нь бэлчээрийн хүрэлцээ, усны хомсдол зэрэг олон асуудлыг үүсгэж байна. Иймд орон нутгийн төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалт, цөлжилт, худаг усны хүрэлцээ, мал сүргийн бүтэц зэрэг асуудлыг бие даан шийдвэрлэх зорилгоор сум, дүүргийн ИТХ–д малын тоо толгойн албан татварыг хуульд заасан хязгаарт багтаан бие даан тогтоож ОНХС–даа /Орон нутгийн хөгжлийн сан / хуримтлуулан зарцуулах эрхийг бий болгож, малын тоо толгойн албан татварыг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, малчдын саналд үндэслэн тулгамдсан асуудлаа шийдвэрлэх зарцуулахаар тусгасан байна.

2019 оны малын өсөлтийн тоог харгалзан малын хөлийн татвар тооцоход хонь, ямаанд хамгийн өндөр, тэмээнд хамгийн бага татвар ноогдож байна. Малын хөлийн татвартай болохгүй бол бэлчээр доройтох, малын чанар муудах, малчид бэлчээрээ булаацалдан маргаан үүсэх, их малтай нь илүү их бэлчээр талхалж нутаг ус доройтуулж байгаа тул татварын бодлогоор зохицуулалт хийх зайлшгүй шаардлага үүсэж байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг авч үзвэл



Хэнтий, Булган, Дорнод зэрэг аймгуудын жишээнээс харахад сумдын малын тоо толгойд тогтоосон мөнгөн дүн адуунд 300–1500 төгрөг, үхэрт 250–1000 төгрөг, тэмээнд 100–1000 төгрөг, хонинд 100–500 төгрөг, ямаанд 270–1000 төгрөг тус тус байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг авч үзвэл

Сум	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Хөнгөлөлт
Халхгол	1000	1000	0	300	1500	200 хонин толгой
Хөлөнбуйр	1000	700	0	300	500	200 хонин толгой
Сэргэлэн	500	500	0	800	1200	–
Дэлгэрцогт	1000	1000	0	400	500	БИНХ тогтоох
Батширээт	1500	1000		800		Нийт малын 30%
Өмнөдэлгэр	1000	800	0	700	400	10 бод, 100 бог
Хайрхан	1000	800	1000	500	600	Чөлөөлөлт үгүй

График 1. Малын тоо толгойн албан татвар тогтоосон байдал

2.3 Сургалтын арга зүй

Дөхүүлэх асуултын арга:

Энэ сургалт иргэдийн амьдралын мэдлэг ур чадвар дээр тулгуурлаж явагдах тул дөхүүлэх асуултын арга ач холбогдолтой. Асуултууд нь суралцахуйн чухал үр дүнтэй холбогддог ба сургалтын агуулгыг цааш үргэлжлүүлэхээс өмнө эгзэгтэй үед хэрэглэнэ. Оролцогчид биеэ барьсан идэвхгүй үед болон хариултын олон хувилбарууд гарч ирэхгүй байгаа нөхцөл байдалд ашиглана. Бусад оролцогчдын санаа бодлыг сонсох, хариултыг хэлэлцүүлэг болгон өрнүүлэх Малчдын амьдрах ухааны чадварыг дэмжих, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх дэд хөтөлбөр.

Бусад оролцогчдын санаа бодлыг сонсох, хариултыг хэлэлцүүлэг болгон өрнүүлэх арга:

Сургагч багш та оролцогчдын хариултыг сонсож байхдаа тэдний сэтгэлгээг нээж өгөхийн тулд бусад хүмүүс энэ санааны талаар юу бодож байгааг асуух хэрэгтэй. Бусдынхаа дэвшүүлсэн асуудал, санааг илүү сайн ойлгох, улмаар ташаа ойлголтын талаар илүү сайн тунгаах боломж олгоно. Тухайлбал, “Түүний хариултын талаар та юу бодож байна?” “Та түүний хариултыг илүү нарийвчилсан байдлаар, эсвэл энгийнээр ойлговол яаж илэрхийлж хэлэх вэ” “Та бидний сонссон бүх хариултыг нэгтгээд нэг өгүүлбэрээр юу гэж хэлмээр байна?” гэх мэтээр нэг талаас оролцоог хангах, нөгөө талаас санаа бодлыг нэгтгэх, ойлголтын зөрүүг гаргах, дүгнэлт хийхийг оролцогчдоор гүйцэтгүүлж буй хэрэг юм.

Чиглүүлэх асуултууд

- Танай аймаг, сумын малын тоо толгойн албан татвар хэд вэ?
- Малын тоо толгойн албан татварын хууль хэрэгжиж эхэлснээс хойш малчдын ямар өөрчлөлт, хандлага гарч байна вэ?
- Малын тоо толгойн албан татварын хууль хэрэгжиж эхэлснээр давуу тал байна уу?
- Малын тоо толгойн албан татварын хууль хэрэгжиж эхэлснээр сул тал байна уу?
- Малын тоо толгойн албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх нь зөв үү?
- Малын тоо толгойн албан татварын хууль хэрэгжсэнээр тулгамдаж буй ямар асуудал байна вэ?
- Албан татвараа төлсөн малчдад төсвөөс ашиг хүртэх, урамшуулал олгох хэлбэрийг та юу гэж бодож байна вэ?
- Сумын ажлын хэсэгт иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл буюу сумын бэлчээр ашиглагчдын холбоодын төлөөллийг оруулах нь зөв үү?
- Малчдын татварын боловсролыг дээшлүүлэх, хууль болон орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын асуудлаар сургалт, мэдээлэл өгөх шаардлагатай юу?
- Малын тоо толгойн албан татвар тогтоосноор таны амьдралд гарсан өөрчлөлт?
- Татвараас чөлөөлөх малын тоог өрхийн хэмжээнд тооцсон нь зөв үү?

Кейс тохиолдлыг задлан шинжлэх арга зүй:

Дараах кейс тохиолдлуудыг уншаад задлан шинжилж, ярилцан, багаар ажиллах

Кейс –1



Малчин Болд тэмээ–10, адуу–50, үхэр–80, хонь–450, ямаа–670 малтай бөгөөд тус сум малын тоо толгойн албан татварыг адуу–1000 төгрөг, үхэр–700 төгрөг, хонь–300 төгрөг, ямаа –1500 төгрөгөөр тогтоосон байна. Тэгвэл малчин Болд жилд хэчнээн төгрөгийг малын тоо толгойн татварт төлөх вэ? Малчин Болдын амьдардаг сумын нийт малчин өрх 10680 бол хэдэн төгрөгийн орлого сумын ОНХС–д төвлөрөх вэ?

2–3 оролцогчийг баг болгон, багт кейсийг өгч, тооцоолол хийлгэж, асуултад хариулахдаа бодлоо цэгцлэх, хариултаа олох боломжийг олгоно. Зөвхөн 1 малчны хувьд малын тоо толгойн албан татвараас хэчнээн төгрөг төвлөрөх талаар харилцан ярилцаж, сумын хэмжээнд төвлөрөх орлогыг тооцуулна. Ийм хэмжээний төвлөрсөн санхүүжилтээр бэлчээрийг сайжруулах, хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх боломжтой юм гэдгийг ярилцан, санал бодлыг сонсох байдлаар сургалтыг үргэлжлүүлнэ.

2.4 Эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилтийн үндэс:

Малын тоо толгойн албан татварын тухай хууль нь 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан бөгөөд уг хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. <http://www.khural.mn/n/9udor/>

Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлж, Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар гамшгийн улмаас хорогдсон бол нотлох баримтыг үндэслэн түүнийг албан татвар ногдуулах нийт малын тооноос хасна гэж заасан байдаг.

Албан татвар ногдуулах, малын тоо толгойг тодорхойлох зорилгоор холбогдох төрийн байгууллага, эрх бүхий этгээд мал тооллого, бүртгэлийн мэдээлэл, гамшгийн улмаас хорогдсон мэдээллийг татварын албанд гаргаж өгөх үүрэгтэй байна.

2021 оны 1-р сарын 1-ээс мөрдөж байгаа энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа бүх малд татвар ноогдуулах болсон.

Тухайлбал доорх схемээс харж болно.



Схем 1. Төсвийн тухай хуулийн 60.2.8-р хуульчилсан заалт

2021 оны 01 сарын 18-ны өдрийн ТEG-н даргын тушаалаар Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.2 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 77.7.3 дахь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7.4 дэх заалтуудыг үндэслэн дараах байдлаар баталсан байна.

1. “Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам”-ыг 1 дүгээр хавсралт
2. “Малын тоо толгойн албан татварын тайлангийн маягт ТТ-31”-ыг 2 дугаар хавсралт
3. “Малын тоо толгойн албан татварын тайлангийн маягт”-ыг 3 дугаар хавсралт
4. “Малын тоо толгойн албан татварын тайлангийн залруулах хүсэлт”-ийг 4 дүгээр хавсралт,
5. Нөхөх зааврыг 5 дугаар хавсралт

2020.11.13-ы өдрийн УИХ-ын чуулганы хуралдаанаар “Төсвийн тухай хууль”-д 60.2.8 заалт орсон. Энэ заалтаар “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн эх үүсвэрт Малын тоо толгойн албан татварын орлогыг нэмэлтээр тусгасан.

Төсвийн тухай хуулийн 23.8 заалтад Сумын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ.
8.15 заалтад Малын тоо толгойн албан татвар гэж заасан байдаг.

Малын тоо толгойн албан татварын хууль гарсантай холбогдуулан хураасан орлогыг зарцуулах чиглэлийг Төсвийн тухай хуулийн 60.2.8-р хуульчилсан байна. **Үүнд:**

1. Бэлчээрийн менежментийг сайжруулах;
2. Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;
3. Малын эрүүл мэндийг хамгаалах;
4. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
5. Малын чанарыг сайжруулах;
6. Гэмт халдлага, гамшгаас хамгаалах;
7. Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;
8. Малын тэжээлийн ургамал тариалах;
9. Тэжээлийн нөөц бүрдүүлэх;
10. Байгаль орчныг хамгаалах;
11. Хортон мэрэгчидтэй тэмцэх;
12. Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа.

Малчин өрх, мал бүхий этгээдээс малын тоо толгойн албан татвар авах нь дараах ач холбогдолтой. **Үүнд:**

- Малын тоог хэт өсгөж, бэлчээрийн даацыг хэтрүүлж, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх байдлыг хязгаарлах;
- Малын тоо толгойн албан татвараас цугласан хөрөнгийн эх үүсвэрийг орон нутагтаа малын чанар, эрүүл мэндийг сайжруулах, бэлчээр нутгаа хамгаалах зэрэгт зарцуулах боломж бүрдэх;
- Малчид малын тоог өсгөхөөс илүү чанарт анхаардаг болж, малаа эдийн засгийн эргэлтэд оруулж ашиг, орлогоо нэмэгдүүлнэ

Мөн татварын нийтлэг зарчимд тусгаарласан байх ёстой. **Үүнд:**

- Тэгш байх – ижил орлогоос ижил татвар авах
- Тодорхой байх – энгийн бөгөөд ойлгомжтой байх
- Хэрэгжүүлэхэд хялбар байх – зардал бага гаргах
- Татвараас зайлсхийхийг хязгаарлах – аливаа хөнгөлөлт чөлөөлөлтийг хязгаарлах
- Уян хатан байх – татвар авагч төлөгчийн хэрэгцээ, онцлогийг харгалзах

Малын тоо толгойн татвар тогтоосноор дараах давуу талууд харагдаж байна. **Үүнд:**

1. Малаас авах албан татварын хэмжээг малын төрөл тус бүрээр тогтоосон байдал
2. Тоо толгойн хувьд цөөн байгаа, бэлчээрт учруулах хохирол багатай тэмээнээс авах татварын хэмжээг ихэнх сумдад 0 /тэг/ байхаар тогтоосон байдал
3. Зарим сумд татвараас чөлөөлөх ямар нэгэн хөнгөлөлтийн асуудал тусгаагүй нь татварын зарчимд нийцэж байна.
4. Татварын хууль хэрэгжиж эхэлж байгаа ч үр дүн харьцангуй сайн
5. Татварын хэмжээг аймаг, сумын ИТХ–аар хэлэлцүүлэн тогтоож сум бүр санхүүгийн эх үүсвэртэй болж, үр ашигтай зарцуулах эрх сум орон нутагт нээлттэй болж байна.

Манай орны малчдын хувьд интернэт орчин хангалтгүй, тайлагнах мэдлэг чадвар дутмаг, хугацаандаа татвараа төлдөггүй, заавал гаднын тусламж дэмжлэг хүсдэг хандлагатай болсон зэрэг нь энэхүү хуулийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал болоод байна.

Эрдэмтэн, судлаачид энэхүү хуулийн хэрэгжилтийг судалж, “Нүүдлийн эдийн засаг” 2021оны судалгааны ажилд малын тоо толгойн албан татварын талаар эдийн засгийн үүднээс тайлбарласан байна. Тухайлбал ИТХ–аас татварын хэмжээг тогтоохдоо бага малтайд нь бага татвар ногдуулж, хөдөө рүү хөгжлийг хүргэхийн тулд татварын зөв харилцаа үүсгэх ёстой юм. Тавин толгой малтай хүн малаа зарах биш 200–д хүргэх сэдлийг бий болгох ёстой. Татварын зөв харилцаа хөдөөд хөгжлийг аваачих нэг хэрэгсэл боловч одоогийн хуулиар нийгмийн энэ асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй. Малынх нь тоогоор малчдын нийгмийн давхрааг тогтоох бүрэн боломжтой гэсэн үнэлэлт өгсөн байна.

2.5 Цаашид авах арга хэмжээ, анхаарах асуудал

- Хил залгаа сумдын татварын хэт ялгаатай байдлыг багасгах
- Татвараас чөлөөлөх малын тоог өрхийн хэмжээнд тооцсон нь шударга биш байна. /Өрхийн гишүүдийн тоо харилцан адилгүй/, зайлшгүй чөлөөлөх шаардлагатай гэж үзвэл өрхийн гишүүдийн тоог харгалзах хэрэгтэй.
- Сумын ажлын хэсэгт иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл буюу сумын бэлчээр ашиглагчдын холбоодын төлөөлөл заавал орсон байх;
- Малчин өрх нэг бүр саналаа өгснөөс малчдын хэсэг, бүлгээр нийлээд санал өгвөл хүртээмж илүү болох;
- ОНХС–ийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил үйлчилгээний саналыг татвараа төлсөн малчдаас авах, ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэж ажил үйлчилгээг санхүүжүүлэх, иргэний нийгмийн байгууллагын оролцоо, хяналтыг хангах асуудлыг сайжруулах
- Малчдын татварын боловсролыг дээшлүүлэх, хууль болон орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын асуудлаар сургалт, мэдээлэл өгөх;
- Татвараа төлсөн малчид хэрхэн төсвөөс ашиг хүртэх талаар тодорхой болгох;

Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах арга зам нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлчээрийн даац хэтрэлтийг бууруулах, хэвийн хэмжээнд барих, бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх санхүүгийн эх үүсвэр бий болох үндэс суурь тавигдсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг үндэслэнэ.

Эдгээрийг хэрэгжүүлэхэд “Орон нутгийн хөгжлийн сан” (цаашид “ОНХС”)–гийн журамд (2021.) зааснаар дараах эх үүсвэрийг санхүүжүүлэхээр тусгасан байна. **Үүнд:**

1. НӨАТ;
2. Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого;
3. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;
4. Хайгуул хийх, олборлолт хийх тусгай зөвшөөрлийн орлого зэрэг төсвийн орлогын тодорхой хувиар тооцож бүрдүүлдэг;
5. Малын тоо толгойн албан татварын орлого;

Мөн тус сангийн хөрөнгөөр орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, гэрэлтүүлгийг сайжруулах, бэлчээрийг хамгаалах, инженерийн хийцтэй худаг гаргах, булаг, шандыг хамгаалах зэрэг олон салбарын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулж байна.

Хэсэг, бүлгийн зохион байгуулалтад орсон малчид ОНХС–ийн саналыг 2 хэлбэрээр авна.

Санал асуулга, бүлгийн ярилцлага: Багийн Засаг дарга нь айл, өрхүүдээр явж саналын хуудас бөглүүлж эсвэл иргэн өөрийн биеэр баг, хороон дээрээ очиж бөглөж саналаа өгнө. Иргэд бүлгийн ярилцлага хийх тохиолдолд багт 30–аас доошгүй, алслагдсан багт **20–аас доошгүй (малчдын төлөөллийн байгууллага болох хэсэг бүлэг–ийн ахлагч санаачлан БАХ–ийн гишүүн малчид хамтран хийх ажлын саналаа гаргана. БАХ–ийн төлөвлөгөөнд тусгасан ажлаа санхүүжүүлнэ)** иргэний бүрэлдэхүүнтэй бүлгийн ярилцлага хийж “ОНХС–ийн үйл ажиллагааны журам”–ын 3 дугаар хавсралтын дагуу тэмдэглэл үйлдэн, иргэдийн гарын үсгээр баталгаажуулна.

Цахим хэлбэр: Одоогоор нийслэлийн 6 дүүргийн зарим хороодод гар утсанд зориулсан санал авах аппликэйшнийг туршиж байна. Мөн зарим сум, багууд мэйл болон интернэт ашиглан санал асуулга авах үйл ажиллагааг туршиж байна.

ОНХС–н үйл ажиллагаа нь төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын гэсэн 3 үе шаттай. Эдгээр 3 үе шатанд сум орон нутагт хэрхэн анхаарахыг авч үзье.

Үйл ажиллагааны төлөвлөлтийн үе шатанд

1. Багийн Засаг даргад саналаа гаргана (Жил бүрийн 1–6 дугаар сарыг дуустал санал асуулгын хуудас бөглөх, бүлгийн ярилцлага, БАХ–ийн гишүүд хамтран санал гаргана, цахим хэлбэрийн аль нэгээр)
2. Иргэдийн нийтийн хурал (6–р сард багтааж зохион байгуулна. Малчид болон БАХ–аас гарсан саналуудыг тусад нь эрэмбэлж, санал хураах хуралдаанаар баталж сумын ЗД–д хүргэнэ.
3. Сумын ОНХС–ийн ажлын хэсэг саналуудыг нэгтгэж эрэмбэлнэ. (Ажлын хэсэгт сумын бэлчээр ашиглагчдын холбооны тэргүүн орсон 7–оос доошгүй гишүүнтэй байна, нийт саналыг эрэмбэлнэ, зөвлөмж дүгнэлт гаргана. 7–р сард багтаана;
4. Сумын Засаг дарга нь Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.
5. Сумын Засаг дарга нь нэгдсэн жагсаалтыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд төсвийн хамт өргөн мэдүүлнэ. Сумын бэлчээр ашиглалт, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын төлөвлөгөөтэй тус тус уялдуулан боловсруулна
6. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь нэгдсэн жагсаалтыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр хэлэлцэн батална. Хяналт тавина.

Гүйцэтгэлийн үе шатанд тухайн шатны ИТХ–аар баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.2–р заалт болон 7.1.2. тендер шалгаруулалтын онцгой журам; хязгаарлагдмал тендер шалгаруулалт, харьцуулалт, шууд гэрээ, 7.1.3. зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам, 7.1.4. олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмуудаар зохицуулагдана.

Сангийн яамнаас баталсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”–ын дагуу зохион байгуулж болно. (Хамтран ажиллах гэрээтэй БАХ–ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, гүйцэтгэнэ. 20 сая төгрөг) **Бага үнийн дүнтэй энгийн худалдан авалтад худалдан авах ажиллагааны журмыг мөрдөхгүй байж болно.**

Тайлагналын үе шатанд

1. Багийн Засаг дарга нь сумын ЗДТГ–тай хамтран өмнөх оны ОНХС–ийн үйл ажиллагааны үр дүн, тухайн онд санхүүжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэж мэдээ мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2 дугаар сард багтаан **олон нийтэд танилцуулна. (БАХ бүрд танилцуулна)**
2. Сумын Засаг дарга нь ИТХ–аар батлагдсан ОНХС–ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдийн өгсөн санал багтсан болон багтаагүй шалтгааныг тухайн саналыг ирүүлсэн багийн Засаг даргаар дамжуулан **иргэдэд заавал мэдээлнэ. (БАХ бүрд мэдээлнэ)**

ОНХС–н үйл ажиллагааны журам:

Орон нутгийн хөгжлийн санг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаанд энэ журмыг баримтална. ОНХС–ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг үндэслэнэ.

Сангийн сайдын 2021 оны 05 сарын 14 ны өдрийн 86–р тушаалаар батлагдсан бөгөөд энэхүү журмын 1.2; 2.7; 3.2.1; 3.5.1; 4.4.6; 5.1–5.4; 6.1–6.4; 8.8; 9.2; заалтуудад тодорхой тусгагдсан байна.

(Эх сурвалж: <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/> –харна уу)

Ажлын хэсэг багаас ирсэн саналыг нэгтгэж, эрэмбэлэхдээ багийн иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн эсэх, сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл болон Газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан эсэх, хөрөнгө оруулалтын төсөвт тооцоог үр ашиг хүртэгчдийн тоонд харьцуулсан байдал зэрэг үзүүлэлтийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган, сумын Засаг даргад хүргүүлнэ.

Сум орон нутгийн түвшинд ямар чиглэлийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгох талаар дэлгэрэнгүй тайлбарлах нь зүйтэй юм. Тухайлбал сумын ОНХС–н үйл ажиллагааны журмын дараах заалтуудад илүү тодорхой зааж өгсөн талаар дурдаж өгнө.

ОНХС–н үйл ажиллагааны журам:

Орон нутгийн хөгжлийн санг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаанд энэ журмыг баримтална. ОНХС–ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг үндэслэнэ.

Сангийн сайдын 2021 оны 05 сарын 14 ны өдрийн 86–р тушаалаар батлагдсан бөгөөд энэхүү журмын 1.2; 2.7;3.2.1;3.5.1;4.4.6; 5.1–5.4;6.1–6.4; 8.8; 9.2; заалтуудад тодорхой тусгагдсан байна.

(Эх сурвалж: <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/> –харна уу)

Ажлын хэсэг багаас ирсэн саналыг нэгтгэж, эрэмбэлэхдээ багийн иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн эсэх, сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл болон Газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан эсэх, хөрөнгө оруулалтын төсөвт тооцоог үр ашиг хүртэгчдийн тоонд харьцуулсан байдал зэрэг үзүүлэлтийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган, сумын Засаг даргад хүргүүлнэ.

Сум орон нутгийн түвшинд ямар чиглэлийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгох талаар дэлгэрэнгүй тайлбарлах нь зүйтэй юм. Тухайлбал сумын ОНХС–н үйл ажиллагааны журмын дараах заалтуудад илүү тодорхой зааж өгсөн талаар дурдаж өгнө. **Үүнд:**

- 4.3.1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;
- 4.3.2. Тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;
- 4.3.3. Хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;
- 4.3.4. ОНХС–ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах;
- 4.3.5. ОНХС–ийн хөрөнгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй уялдуулан төлөвлөсөн байх;
- 4.3.6. ОНХС–ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдан ажлын гүйцэтгэл нь баталгаажсан боловч тухайн онд санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрийг нэгдсэн жагсаалтад оруулах;
- 4.3.7. Сум, дүүргийн ОНХС–ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах.
- 4.3.8. ОНХС–ийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болох хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний өмчлөл, цаашдын ашиглалтын урсгал зардал, шинээр бий болох орон тоог орон нутаг өөрөө хариуцах;

4.4. Сумын ОНХС–ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ. **Үүнд:**

4.4.1. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;

4.4.2. Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;

4.4.3. Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах;

4.4.4. Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;

4.4.5. Сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах;

4.4.6. Мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах;

4.4.7. Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;

4.4.8. Ажлын байр бий болгох;

ГУРАВ. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1 Танхимын бус сургалт үйл ажиллагааны тухай.

Сургалтын явцад багш, оролцогч иргэдтэй эргэх холбоотой байх бөгөөд танхимын бус үйл ажиллагааг ч мөн хамтдаа зохион байгуулах боломжтой. Танхимын бус сургалтын үйл ажиллагааг явуулахаас өмнө багшийн өгсөн даалгавар, төслийг оролцогчид багаараа гүйцэтгэх бөгөөд урьдчилан багийн ажлын төлөвлөлт хийх, ажлаа хуваарилах, танхимаас гадуур ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх зэрэгт багш анхаарна. Мөн төсөл, даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ. Ялангуяа сургалтаас гадуурх багийн ажил, төсөлт ажлыг гүйцэтгэхэд эзэмшсэн мэдлэг, чадвар, сэтгэлгээг бодит нөхцөлд буулгах, хэрэглэхэд түлхүү анхаарах хэрэгтэй. Танхимаас гадуур гүйцэтгэх ажлын удирдамжийг сургагч багш дэлгэрэнгүй байдлаар гаргаж, оролцогчид түүнтэй урьдчилан танилцсан байх шаардлагатай. Оролцогчдын мэдлэг, чадвар, сэтгэлгээг зөвхөн танхимын сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан хөгжүүлэхэд хангалттай бус учраас төсөлт ажил байдлаар, тодорхой дадлага ажлыг багийн зохион байгуулалт, багийн оролцоо, чиг үүргээр дамжуулан хөгжүүлэх хэрэгтэй. Жишээ нь: Оролцогчдыг саахалт болон ойролцоо оршин байгаа баг, хороогоор нь, эсвэл хүсэл эрмэлзэл, сонирхлоор нь баг болгон хувааж, багууд жижиг компани, хоршоо хэлбэрийн зохион байгуулалттайгаар ажиллан дараах үйл ажиллагаанд оролцох байдлаар сургалтын үйл ажиллагааг идэвхтэй хэлбэрээр зохион байгуулж болно. **Үүнд:**

- Бие даасан ажил
- Хос хосоороо ажиллах
- Багаар ажиллах
- Кейсүүдийг цуглуулах
- Дүн шинжилгээ хийх
- Танхимаас гадуур суралцах
- Орон нутгийн аж ахуйгаар зочлох, өрхийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх боломж, санааг олж авах
- Шийдвэр гаргагчид болон хөдөө аж ахуйн маркетинг, менежментийн чиглэлийн мэргэжлийн холбоодын төлөөллийг сургалтад урилгаар оролцуулах, төсөл хөтөлбөрт оролцох, жижиг үйлдвэрлэл эрхлэх зөвлөгөөг авах
- Илтгэл, танилцуулга хийх
- Мэдээлэл харилцааны технологи ашиглах гэх мэт.

3.2 Харилцан суралцах аргаар сургалтыг зохион байгуулах нь:

Энэхүү сургалт нь оролцогчид бие биеэсээ харилцан суралцах арга зүйгээр зохион байгуулагдана. Оролцогчид нутаг нутгийн болон бусдынхаа сайн туршлагыг олж нээх, хамтран суралцах, сайн туршлагыг хямд зардлаар олж эзэмших үйл явц юм. Харилцан суралцах арга нь мэдлэг, мэдээлэл хуримтлуулах, шинэ нөхцөл байдалд асуудлыг шийдэх, шинэ мэдлэг бүтээх, шинэ хэрэглэгчид дамжуулах бүтээлч арга юм. Сургалтаар эзэмшсэн мэдлэг тухайн үедээ шууд хэрэглэгдэж үр дүнг харуулах нь цөөн байдаг бол харилцан суралцах аргаар эзэмшсэн мэдлэг шууд ажилд туршигдан үр дүнг мэдрэх боломжтой байдгаараа онцлогтой. Жишээ нь: Оролцогчдод урьдчилсан даалгавар өгөөд, ноос ноолуур боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, өрхийнхөө хэрэгцээг хангаж байгаа иргэдийн туршлагыг богино хэмжээний бичлэг хийж ирэх даалгавар өгч, сургалтын үеэр түүнийгээ хэлэлцэх, тайлбарлах зэрэг бүтээлч даалгавраар идэвхжүүлж болох юм. Оролцогчдын сайн туршлагыг хуваалцах арга зүйг дараах байдлаар хэрэгжүүлж болно.

Сайн туршлагыг тодорхойлох, хуваалцах алхам

Сургалтад оролцогчдыг хагас дугуй хэлбэрт оруулж зогсоогоод багш (чиглүүлэгч, сургагч багш) бусдын сайн туршлагыг тодорхойлох, тухайн туршлагыг хуваалцах үе шатыг дараах алхмын хамт тайлбарлана.

1. Сайн туршлагыг тодорхойлох “Сайн туршлагыг тодорхойлох” алхмуудыг бичсэн (түлхүүр үгээр) цаасыг байрлуулаад тухайн алхам бүрийг тайлбарлана. Багш туршлагыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг тайлбарлаж өгнө. Өөрсдийн туршлагаа бусадтай хуваалцахаар төлөвлөж буй хүмүүс хамтран ажиллагсад, орон нутгийн иргэдтэй харилцан ярилцаж, хэлэлцэх байдлаар дараах асуултад хариулж сайн туршлагаа тодорхойлно.

- Тухайн туршлагын давуу ба сул талууд, мөн эрсдэлийг тооцоолсон байдлаар тодорхойлон, ярилцах юм. Хэдийгээр сайн туршлага гэж байгаа боловч, хэрэгжүүлэх явцад эрсдэл гарч болох тул сул тал байхыг үгүйсгэх аргагүй юм. Малчдын амьдрах ухааны чадварыг дэмжих, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх дэд
- Тухайн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх боломжтой юу? /Жишээ нь өртөг өндөртэй туршлагыг бусад газарт хэрэгжүүлэхэд нэн ярвигтай байдаг/
- Энэ туршлагыг хэрэгжүүлээд ямар үр дүнд хүрч болох вэ?
- Энэ туршлагыг хэрэгжүүлсний дараа аливаа үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах боломжтой юу?

Хэрэв эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байвал энэ нь хэрэгжүүлж болохуйц сайн туршлага болж чадна.

2. Сайн туршлагыг хуваалцахын ач холбогдол Дараа нь сургагч багш малчин иргэдэд өөртөө байгаа сайн туршлагаа зөвхөн өөрсдийн сайн сайхны төлөө хэрэглээд зогсохгүй үүнийгээ бусадтай хуваалцаж, нийгэмд өөрсдийн хувь нэмрээ оруулах хэрэгцээ шаардлага, ач холбогдолтой байгаа талаар тайлбарлана.

3. Сайн туршлагаас суралцах буюу юуг, хэрхэн хэрэгжүүлэхээ шийдэх, төлөвлөх Багш самбар дээр “Сайн туршлагаас суралцах” гэж бичсэн түлхүүр үгийг байрлуулна. Дараа нь сайн туршлагаас суралцах алхмыг тайлбарлаж өгөөрэй.

- Хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн сайн туршлагыг малчидтай хамтран хэлэлцэж тухайн туршлагын давуу болон сул тал, орон нутгийн болон өрхийн түвшинд ямар эерэг үр дүн гарахыг тодорхойлно.
- Магадгүй хоёр ба түүнээс дээш сайн туршлага байгаа бол эрэмбэ үүсгэх байдлаар сайн туршлагыг сонгон авна.
- Сайн туршлагыг бүтээсэн хувь хүн, орон нутагт очиж туршлага судална. Ийнхүү тухайн туршлагыг хэрэгжүүлсэн бодит байдлыг судлах нь орон нутаг, тухайн өрх гэрт бий болсон өөрчлөлт, сул болон давуу талыг дэлгэрүүлэн судалж, шийдвэрээ эцэслэн гаргахад дэмжлэг үзүүлнэ.

4. Сайн туршлагыг бусадтай хуваалцах Сайн туршлагыг бусадтай хуваалцахдаа ойлгомжтой, дэлгэрэнгүй байдлаар бусдадаа тайлбарлаж өгөхийг сануулаарай. Оролцогчийн туршлагыг өөрийн нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх явцад сонсож буй хүлээн авагч талд ойлгомжгүй асуудал цөөнгүй тохиолдоно. Ийм нөхцөл байдал үүсвэл сайн туршлага бүтээсэн талтай холбоо тогтоон асууж лавлах эсвэл зөвлөх, урих ажлыг зохион байгуулж болох юм. Өөр орон нутагт амжилттай хэрэгжсэн үйл ажиллагаа танайд амжилтгүй хэрэгжиж болзошгүй. Иймд туршлагыг тухайн орон нутгийнхаа онцлогт тохируулж хэрэгжүүлэх шаардлагатайг сургалтад оролцогчдод онцгойлон ойлгуулах хэрэгтэй.

5. Сайн туршлагад тулгуурлан бодлогын нөлөөллийг бий болгох Сайн туршлагаас суралцах, өөрийн болгох үйл явцад хяналт тавьж үнэлгээ хийж болно. Тухайн сайн туршлагыг хэрэгжүүлсэн багуудтай хамтран бодлогод өөрчлөлт оруулах алхмыг хийх нь туршлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой алдаа давтагдахгүй байх боломжийг бүрдүүлнэ. Туршлага солилцох үйл ажиллагааны төгсгөлд сургагч багш сайн туршлагыг тодорхойлох, тухайн туршлагаас хэрхэн суралцах, үе шат бүрт хийгдэх алхмыг зөв чиглүүлж, оролцогчдыг нээлттэй байлгах тал дээр анхаарах ёстой бөгөөд бодит видео хичээл, билэг, зураг дээр тайлбарлаж дүгнэж явбал илүү үр дүнд хүрнэ. Оролцогчдыг хагас дугуй хэлбэрт оруулж зохион байгуулж байгаа нь бие биеэ сонсох, хүлээн зөвшөөрөх, харилцан тэгш эрхтэй байх сэтгэлзүйн орчныг бүрдүүлж буй хэрэг юм. Дараах хүснэгтийн дагуу баримт мэдээллээ цуглуулж авбал өрхийн туршлагууд бодитоор өвлөгдөн үлдэх боломжтой юм.

Сайн туршлагын баримтын товч хүснэгт

Сайн туршлагын нэр		
Хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаа		
Хүрсэн үр дүн (гарсан өөрчлөлтийг нотлох тоо баримт)		
Ашигласан нөөц	Мэргэжил арга зүй, хүний нөөц	Хөрөнгийн эх үүсвэр
Холбоо барих хаяг		
Мэдээлэл өгөх хүний нэрс		

Сайн туршлагын баримтын дэлгэрэнгүй хүснэгт

Сайн туршлагын нэр		
Нөхцөл байдал тулгамдсан асуудал		
Зорилтот бүлэг		
Шалгуур үзүүлэлт (төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ)		
Ашигласан хэрэгсэл		
Хүрсэн үр дүн (гарц, богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)		
Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд		
Тулгарсан бэрхшээл, эрсдэл		
Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс		
Үр шим хүртэгчдийн сэтгэгдэл		
Туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс		

3.3 Тулгарч болох бэрхшээл, шийдвэрлэх аргууд

1. Сургалтын үеэр бүлгүүд ижил төрлийн сайн туршлагыг сонгож давтан ярьснаар сургалтыг уйтгартай болгох үед: Бүлэг тус бүрийг дараалуулан яриулахдаа туршлага давхцуулахгүй байх
2. Сургалтын үеэр цаг хүрэлцэхгүй бол: Хэрэв сургалтын төлөвлөгөө зөв боловсруулагдсан бол чиглүүлэгч төлөвлөгөөний дагуу цагийг баримтлан ажиллах ба цаг хүрэлцэхгүй байх асуудал гардаггүй.
3. Сургалтын туршид зарим оролцогчид “чимээгүй” байдаг. Яаж “нүүр хагарах” вэ? Хэрэв “чимээгүй” оролцогчид байвал тэдэнд бусадтайгаа, олны өмнө гарч, санаа бодлоо хуваалцах санал тавьж болох юм. Ингэснээр тэд ямар бодол, саналтай байгаагаа бусад оролцогчидтой хуваалцах боломжтой болно. Хэрэв тэд цаашид хийгдэх үйл ажиллагаа болон илтгэлтэй холбоотой өөрийн санал бодлоо хуваалцахдаа тааламжтай бус байвал тэднийг өөртөө тохиолдсон ямар ч төрлийн зөрөг туршлагаа хуваалцахыг хүсэж болно. Үүний дараа тэд илүү идэвхжиж, чөлөөтэй оролцож эхэлнэ.
4. Сайн туршлагыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд
 - Уламжлалт аргуудыг сэргээн, шинэчилж, өвлүүлж буй байдал
 - Шинэлэг, үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлж буй
 - Тогтвортой хөгжлийг дэмжиж буй
 - Нийгэмд, бусад айл өрх, иргэдэд хүлээн зөвшөөрөгдөх
 - Түгээн дэлгэрүүлэх/суралцах боломжтой байх
 - Технологийн хувьд боломжтой
 - Оролцоог хангасан, эдийн засгийн хувьд боломжтой

5. Шилдэг туршлага гэж: Монголын нөхцөлд аливаа сайн туршлага олон удаа хэрэгжсэн тохиолдолд “Шилдэг туршлага” гэж тооцож болно.

Сайн туршлагыг хэрэгжүүлэх явцад тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэхдээ туршлага түгээж буй хувь хүн, байгууллагаас зөвлөгөө авч, хамтран ажиллах хэрэгтэй.

Ингэснээр та бүхний сонгосон “сайн туршлага” үр өгөөжтэй хэрэгжих юм.

Дадлага ажил

Сургалтыг дадлага ажил байдлаар бие биедээ туршлагаа дэлгэрүүлж, харилцан суралцах байдлаар зохион байгуулбал илүү үр дүнтэй тул уг сэдвийн хүрээнд 3–4 оролцогчдыг багт хуваан, саналыг бичүүлэн, тайлбарлуулан, нийт оролцогчдын дунд хэлэлцүүлэн, ОНХС–д өөрийн суманд энэ онд бэлчээрийн менежментийг сайжруулах саналыг эрэмбэлүүлэн, дадлага ажил байдлаар зохион байгуулж болно. Багаас төлөөлөл гарч илтгэх, түүнийгээ тайлбарлах, мэдээллийн дагуу түлхүүр асуултыг бэлтгэж, асуудал дэвшүүлж, хэлэлцүүлэг зохион байгуулах гэх мэт байдлаар зохион байгуулах нь сургалтын үр дүнг сайжруулах боломжтой юм.

3.4 Оролцогчдод өгөх нэмэлт мэдээлэл –2

1. Сургалтын үеэр бүлгүүд ижил төрлийн сайн туршлагыг сонгож давтан ярьснаар сургалтыг уйтгартай болгох үед: Бүлэг тус бүрийг дараалуулан яриулахдаа туршлага давхцуулахгүй байх

Монгол Улсад 2019 оны эцсээр 70.9 сая толгой мал тоологдсон бөгөөд 2000 мянган төгрөгөөр тооцвол 142 тэрбум, 1000 төгрөгөөр тооцвол 71 тэрбум төгрөг төвлөрүүлэх боломжтой гэж үзэж байна.

Улсын дунджаар нэг ямаанд 1000 төгрөг, тэмээнээс 150 төгрөг, адуунаас 800 төгрөг, үхрээс 500 төгрөг, нэг хонинд 900 төгрөгийн татвар авахаар тооцож, чиглэл аграсан бөгөөд нэг малаас авах татварын хэмжээг 2000 төгрөгөөс хэтрүүлэхгүй байх хуулийн зохицуулалттай. Сум, орон нутгийн төсөвт төвлөрөх энэ мөнгийг аль болох эргээд малчдад хэрэгтэй зүйлд үр ашигтай зарцуулах, татвараа төлсөн малчин ашиг хүртдэг байхаар зохицуулж буй. Үүнд төр болон иргэд, ТББ–ын Хяналт тавих нь зүйтэй юм.

Малын тоо толгойн албан татварыг бэлчээрийн менежмент хийх, зун, намрын бэлчээрийг хамгаалах, өвөлжөө, хаваржааг сахиулах, малын чанарыг сайжруулах, ус хангамжийг хүртээмжтэй болгох, хадлан тэжээл бэлтгэх, цаг хүндэрсэн үед малчид өвс, тэжээлээ чөлөөтэй худалдан авч байх зэрэг бодит ажилд чиглүүлж, татвар нь орон нутгийн хөгжлийн санд төвлөрч, асуудлыг ИТХ малчид өөрсдөө шийдэж байхаар тусгасан учир энд нутгийн өөрөө удирдах байгууллагын оролцоо их болж буй талаар буйг ХХААХҮЯ–ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас байр сууриа илэрхийлсэн байна



Татварыг орон нутаг өөрсдөө яаж авахаа шийдэж орон нутагтаа юунд зохицуулахаа мөн өөрсдөө хэлэлцэж шийдэж байгаа. Энэ талаар та санал байр сууриа хэлнэ үү?

Тэр талаар манай сум захиргаанаас хүмүүс явж танилцуулж, малчдын татварыг орон нутагтаа зохицуулж, цөлжилт, усжуулалт, бэлчээрийн нөөц тогтоолт зэрэг зүйлд зарцуулбал ямар байна гэсэн санал авч байсан. Энэ бол зөв гэдгийг хэлсэн байна.

Оролцогчдын мэдлэг ур чадвар, өмнөх мэдлэг дээр тулгуурлан тухайн бүс нутгийн зохистой малын тоо толгойн албан татварын хэмжээ, ОНХС–д бэлчээрийн менежментийн чиглэлээр дэмжигдэх саналыг БАХ, хэсгийн түвшинд хэрхэн боловсруулах зэрэг хамгийн их сонирхол татсан, хэрэгцээтэй сэдвийг дэлгэрүүлэн судлах, хэлэлцэх аргаар зохион байгуулж болно.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ДАРААХ ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ

Чиглүүлэгч багш та сургалтыг дүгнэхдээ оролцогчидтой харилцан ярилцаж, тэдний санал бодлыг сонсон, сургалт хэр үр дүнтэй болсон талаар сэтгэгдлийг нь сонсохдоо дараах зүйлсийг анхаараарай. Үүнд:

- Оролцогчдын үзэл бодол, саналыг хүндэтгэх
- Хүн бүрийн үзэл бодол, санал, туршлагаа солилцох боломжтой сургалтын орчныг бүрдүүлэх
- Шаардлагатай тохиолдолд санал хүсэлтийг бичүүлж авах
- Ялгаатай үзэл бодол, санал туршлагыг үндэслэн бүлгийн хэлэлцүүлэг хийх
- Хүмүүсийн итгэл үнэмшил, туршлага, амьдралын хэв шинжид тулгуурлан сургалтыг зохион байгуулахыг бүү мартаарай. Сургалтын дараа санал сэтгэгдэл сонсох хугацаа гаргаж, үр дүнгийн талаарх чөлөөт ярилцлага зохион байгуулах нь илүү үр дүнтэй байдаг.

4.1 СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Бидний зохион байгуулсан сургалтад идэвхтэй оролцсонд баярлалаа. Таны нэр энэхүү үнэлгээний хуудсанд дурдагдахгүй тул сургалтын талаарх санал бодлоо чөлөөтэй илэрхийлээрэй.

Сургалтын талаар сэтгэгдлээ илэрхийлнэ үү.

.....

Сургалтаар эзэмшсэн мэдлэг чадвараас танд хамгийн их хэрэг болохуйц зүйл юу байсан бэ?

.....

Сургалтын аль хэсэг танд хамгийн хэрэгтэй байсан бэ?

.....

Сургалтын аль хэсэг танд ач холбогдолгүй байсан бэ?

.....

Та сургалтаас сурсан зүйлсээ хэрхэн хэрэгжүүлэх вэ?

.....

Танд сургалтыг сайжруулж, өөрчлөх ямар нэгэн санал байна уу?

.....

Бусад:

.....

Сум /хороо:

Нас:

Хүйс:

Гарын авлагыг хэрхэн бүтээсэн талаар

“Бэлчээрийн тогтвортой менежментэд малын тоо толгойн албан татварын ач холбогдол” сэдвийг судлаач Ш.Гэрлээ PhD, ХААИС. судлаач Н.Ганхуяг, МБАНХ хамтран боловсруулсан бол сургалтын аргазүй, зохион байгуулалт, үнэлгээний хуудас хэсгийг боловсруулахдаа “Малчдын амьдрах ухааны чадварыг дэмжих, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд бэлтгэсэн “Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, технологи” сэдэвтэй сургагч багшид зориулсан гарын авлагаас санаа авсан болно.

Гарын авлагын талаар санал зөвлөмжөө бидэнд ирүүлээрэй, хамтран ажилласан бүх хүмүүстээ баярлалаа.